

М.К.ГАНДИ - ХУЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ ТЭМЦЭГЧ

*Ж.Энхбаяр**

1948 оны 1 дүгээр сарын 30-нд тусгаар тогтнолоо тунхаглаад ердөө хэдэн сар болж байсан Энэтхэг оронд хар өдөр тохиож, ардчилал, эрх чөлөөнд хөтөлж хүргэсэн, “эцгээ” алдаж өнчрөв. Энэ бол Гэгээрсэн Бурхан Багшаас хойш Энэтхэг түмний дунд тодорсон хамгийн аугаа хүн¹ Мохандас Карамчанд Ганди хинди тэрс үзэлтний гарт амь үрэгдсэн хэрэг байлаа. Тусгаар тогтносон Энэтхэг улсын анхны ерөнхий сайд Жавхарлал Неру эмгэнэлийн үгэндээ “Би (үгийнхээ эхэнд) манай гэрэл унтрав гэсэн нь буруу байсан. Биднийг гийгүүлж байсан тэр гэрэл ердийн нэг гэрэл байгаагүй юм. Олон жилийн туршид энэ орныг гийгүүлж байсан шигээ мянга мянган жилийн турш энэ оронд үзэгдсээр байх болно. Дэлхий ч харах болно. Энэ гэрэл амьд... мөнхийн үнэнийг илтгэж бидний зам зөв гэдгийг сануулж, алдаа эндэгдлээс хаацайлан эртний түүхт энэ орныг эрх чөлөөнд хүргэсэн юм”² гэжээ. Ганц Энэтхэг түмэн ч бус харанхуйг гийгүүлсэн тэр гэрлийг дэлхий даяараа харж, ард түмнийхээ сайн сайхны төлөө асан дүрэлзсэн тэр гэрэлт бамбарыг үе үеийн тэмцэгчид өртөөлөн буухиалж өнөөг хүргэжээ.

Аливаа хүчирхийлэл, ялгаварлан гадуурхах шударга бус явдлын эсрэг тэмцлийн бамбарыг барьж, энх тайвны бэлгэ тэмдэг болон дэлхий даяар алдар нэр нь түгсэн Махатма Ганди 1869 оны 10-р сарын 2-нд Гужарат мужийн Порбандар хотод мэндэлжээ. Энэтхэг түмэн “Вапу”-гийнхаа³ мэндэлсэн энэ өдрийг үндэсний баярын өдөр болгон тэмдэглэдэг. Англид хуулийн боловсрол эзэмшсэн тэрбээр Энэтхэг орондоо буцаж очин өмгөөлөгчөөр ажилласан боловч амжилтгүй байлаа. Тэгээд Өмнөд Африкт мэргэжлээрээ нэг жил ажиллах гэрээ байгуулж, 1893 оны 5-дугаар сард Дурбан хотноо хүрэлцэн ирсэн байна. Ирээд долоо найм хоносны дараа Дурбанаас Преториа орохоор галт тэргээр гарчээ. Нэгэн цагаан арьст хүний гомдлоор дээд зэрэглэлийн ерөөнөөс гарах шаардлагыг үл биелүүлсэн учир түүнийг галт тэрэгнээс Марицбург өртөөн дээр хүчээр буулгажээ.⁴ Энэ явдал түүний амьдралыг бүхэлд нь, ертөнцийг үзэх үзэлд нь гүнзгий өөрчлөлт оруулсан юм. Өртөөн дээр дараагийн галт тэргийг хүлээн суухдаа өөрийн үүрэг юу билээ, эрхийнхээ төлөө тэмцэх үү, эс бөгөөс Энэтхэг рүүгээ буцах уу хэмээн элдвийг бодож, үүргээ үл биелүүлэн Энэтхэг рүүгээ буцах нь аймхай хулчгар хэрэг болно хэмээн үзэж арьсны үзлийн эсрэг тэмцлийн тухай санаа орж ирсэн байна. Ийнхүү Энэтхэг цагаачид хэрхэн галдуурхагдан

* Ж.Энхбаяр - ФСЭХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

аж төрж буйг нүдээр үзэж, өөрийн биеэр хавчлага дарамтын зовлонг мэдэрч энэтхэг түмэнтэйгээ нэгдэн шударга бус байдалтай тэмцэхээр сэтгэл шулуудсан байна. Хуульчийн ахиухан орлоготой ажлаа орхиж, дэгжин костюмаа тайлан, бэлгийн амьдралаас татгалзаж,⁵ нэг үгээр хэлбэл энэ биеийн жаргалыг огоорон энэтхэг ахан дүүсийнхээ төлөө тэмцэхээр шийдсэн. Олсон боловсрол, эзэмшсэн мэргэжлийн дагуу нэг хийгээд хэсэг хүнийг өмгөөлж байсан тэрбээр нийт түмнээ өмгөөлөх эрхэм их үйлсийг гүйцэтгэхээр ханцуй шамлан орлоо.

Одоогоос зуун жилийн тэртээ 1906 оны 9-р сарын 11-нд Жоханнэсбург хотын Эмпари театрт 3000 гаруй энэтхэгчүүдийн төлөөлөл цугларан арьсны үзэлтнүүдийн эсрэг хэрхэн тэмцэхээ хэлэлцсэн байна. Нэгэн мусальман эрийн гаргасан саналын дагуу цагаан арьстнуудын эсрэг шударга бус, арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан хуулийг үл биелүүлж тэмцэхийг Ганди цугларсан олонд хандаж уриалжээ. Хуульч хүн хуулийг үг үсэггүй даган биелүүлэх мэргэжлийн үүрэгтэй, гэвч тэрбээр шударга ёсыг дээдлэж ёс суртахууны үүргээ чанд сахисан. Тэрбээр эд хөрөнгөтэй ч бай, үгээгүй ядуу ч бай хэнд ч болов буун дуу гаргалгүй хүч үл хэрэглэн эрх чөлөөнд хүрэх зэвсэг бий гэдгийг итгүүлж үнэмшүүлсэн юм. Хэрэв шударга бус, ёс суртахуунд харшилсан хууль байх аваас үл биелүүлэх тухай Америкийн зохиолч Давид Ториав “Иргэний үүргээ үл биелүүлэхүй”⁶(1849) хэмээх бүтээлдээ анх дэвшүүлэн тавьсан аж. Эрх баригчид Ганди тэргүүтэй хэдэн мянган тэмцэгчдийг хууль үл биелүүлж хамтран ажиллахаас татгалзсаных нь төлөө барьж хорьж байлаа. Ийнхүү сатьяграх хөдөлгөөн төрөн гарч Өмнөд Африк дахь арьс өнгөөр ялгаварлан гадуурхахын эсрэг тэмцлийг өрнүүлсэн бол хожим нь Энэтхэгийг Британиас чөлөөлөх тэмцлийн үндсэн зэвсэг болсон юм. “Үгээгүйчүүд энэ бол бидний эх орон гэж боддог болтол; дуу хоолойгоо сонсгож чаддаг болтол; доод хийгээд дээд анги гэж байхгүй болтол; нийгмийн бүх анги давхраа эв найртай аж төрөх хүртэл би Энэтхэгийн төлөө зүтгэх болно”⁷ хэмээн бичиж байлаа. Зөвхөн Энэтхэгийг чөлөөлөх нь хангалттай бус, дэлхийн ихэнх улс орон, ард түмэн эрх чөлөөгүй, колонийн дарлалд зовж байгааг харж ойлгож байсан юм. Гагцхүү эртний их түүх, баялаг уламжлалтай Энэтхэгийг чөлөөлж гэмээнэ дэлхийн зовсон олон түмнийг босоход нөлөөлнө хэмээн үзэж байсан. “Бид дэлхий даяар дарлагдан зовсон олон сая хүнийг, бүх дэлхийг чөлөөлөх ёстой, дэлхий даяараа Энэтхэгийг гайхамшиг бүтээхийг харж байна”⁸ хэмээн 1931 онд тэрбээр Энэтхэгийн Үндэсний Конгресс намын хурал дээр хэлжээ. Тэрбээр өөрийн номлол сургаалаараа нийтийн хүчийг нэгтгэж Британийн эзэнт

гүрнийг донсолгоод зогсоогүй Ази, Африкийн олон улс оронд эрх чөлөөний төлөөх тэмцлийн үүд хаалгыг нээсэн юм.

Ганди өмнө дурдсан Давид Ториав, Оросын их зохиолч Лев Толстой нарыг уншиж, хинди, буддизм зэрэг Энэтхэгийн олон шашинд номлодог ахимса буюу хүч үл хэрэглэх сургаалын зарчимд үндэслэн сатьяграх хөдөлгөөний үзэл санааг боловсруулсан юм. Ингэж тэрбээр шударга бус хууль тогтоомжийг үл даган биелүүлэх, хүч үл хэрэглэх тэмцлийн замыг улс төр, нийгмийн тавьсан зорилгод хүрэхэд ашигласан байна. Нийтээрээ эв найртай энх амгалан, эрх тэгш аж төрөх Гандийн үзэл санаа нь Энэтхэг түмний нийгэм улс төрийн сэтгэлгээний үндсэн онцлогийг тусгаж байдаг. Хинди, буддизм, ислам, христос гээд дэлхийд байгаа бүх шашин шүтдэг, олон хэл аялгуугаар ярьдаг, олон үндэстэн ястнаас бүрэлдэх нэг тэрбум илүү хүнийг үүнээс өөрөөр тогтоон барих боломжгүй, зөвхөн хамтдаа эв найртай харилцан хүндэтгэл, ойлголцлын зарчим дээр үндэслэсэн эрх чөлөөний хөдөлгөөн л биелэлээ олох учиртай байсан юм. Тухайн үеийн Энэтхэгийн зарим удирдагчид Гандийн сонгосон тэмцлийн аргыг сайшаахгүй байсан бөгөөд Гандийн хэтийн зорилго үл гүйцэлдэх шинж чанартай гэж үзэж байлаа. Гэвч Гандийн сонгон боловсруулсан тэмцлийн арга зөв байсныг түүх нотолж энэтхэг түмэн Цаст Гималайн уулс, ариун Ганга мөрөндөө эзэн суусан билээ. Ийнхүү тэрбээр “сатьяграх” хэмээх хүч үл хэрэглэх нийтийн хөдөлгөөнийг үндэслэж Энэтхэгийн ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө, шударга ёс, эв нэгдлийн төлөө, ялгаварлан гадуурхахын эсрэг идэр залуугаасаа насан өөд болтлоо тэмцсэн ажгуу.

Гандийн хувьд үнэн бол шашны хамгийн дээд хэлбэр, үнэнийг олох нь түүний тэмцлийн тулгын чулуу нь байлаа. Тэрбээр “сатьяграх бол үнэний эрэл юм, Үнэн бол миний бурхан юм. Хүч үл хэрэглэх нь үнэнийг ухаарах арга юм”⁹ хэмээжээ. Хүн болгон үнэнийг олохийн төлөө амьдралаа зориулах ёстой гэж үзэж байв. Хүчирхийллийн эсрэг хүч хэрэглээд явцгүй байдлыг хурцатгаж улам муутгана, харин хүч үл хэрэглэх нь цорын ганц арга, хүч үл хэрэглэх явдал бол дайны эсрэг үзлээс илүү гүн агуулгатай, энэ бол амьдралын учир зорилгын тухай бидний амьдарч буй байдлаас урган гарсан үзэл мөн. Хүчирхийлэл бол бидний төрөлх шинж биш юм, хэрэв тийм бол хүн хүнээ алж хядахын тулд цэрэг дайны бэлтгэл сургууль хийх шаардлага байхгүйсэн. Олон сэтгэгчид дайн, нийгмийн зөрчил мөргөлдөөн гарцаагүй гэж үздэг ч, Ганди буруу үйлдэлд хүч хэрэглэх аргаар хариу өгөхийг эсэргүүцдэг байлаа. “Харанхуйг харанхуйгаар нь арилгаж болдгийг хэн нэгэн надад баталж өгсөн цагт хүчирхийллийг хүчирхийллээр ялах болно” хэмээн

Ганди хэлсэн билээ. Түүний үзлээр хүчирхийллийг зөвхөн бие биенээ хайрлах, хүндэтгэх хийгээд ухаарсаны үндсэн дээр даван туулна. Хүч үл хэрэглэх гэдэг нь нэг хацраа алгадуулаад нөгөө хацраа өгөхийн нэр биш харин дайснуудыг найз нөхөд болгох арга юм. Хүч үл хэрэглэх нь амьтай бүхнийг хүндэтгэж буй дээд ёс суртахуун бүхий үйлдэл мөн бөгөөд их хайр, хүндэтгэл, ухаарал юм. Ганди дайснаа үзэн ядах, уурлан бухимдахыг хүлээж авдаггүй байсан ба харин тэднийг хүндэтгэж хайрлах нь тэднийг дийлэх нөхцөл мөн гэж номлосон.

Энэ оны 9-р сарын 11-нд Махатма Гандигийн сатьяграх хөдөлгөөний 100 жилийн ой тохиож дэлхий дахинаа даруухан тэмдэглэлээ. Хөдөлгөөн төрөн гарч өсөж өндийсөн эх орон Өмнөд Африкт бүтэн жилийн туршид тэмдэглэхээр болжээ. Мөн өдөр Америкийн Нью-Йорк, Вашингтон хотуудад болсон халдлагын таван жилийн ойг тэмдэглэсэн билээ. 2001 оны 9-р сарын 11-нд хүн төрөлхтний шашин хоорондын зөрчил, үзэн ядалтыг гааруулж, айдас дагуулсан шинэ эрин үеийг авч ирсэн. Эндээс улбаалан “Терроризмийн эсрэг дайн” эхлэв. Ийнхүү нэг хэсэг нь шашны нэр барин халдлага үйлдэж, бүтээн босгосон бүхнийг сүйтгэж байхад нөгөө хэсэг нь ардчилал, эрх чөлөөний нэрээр хариу хүч хэрэглэх бөлгөө. Энэ бол Гандийн номлолд харш юм. Хүн төрөлхтөнд Гандийн өв уламжлалаас суралцах хэрэгцээ шаардлага улам өсөн нэмэгдэж байна. Тэрбээр шашин хоорондын зөрчлийг олж харах гэж бүх шашны хөлгөн судруудыг уншиж амьдралынхаа эцсийн мөч хүртэл эвлэрэл зохицлын төлөө явж ирсэн. Шашны харьцуулсан судалгаа хийж энэ талын барагдашгүй их өв үлдээсэн юм. Гандийн үзэл санааны нөлөөн дор олон тэмцэгчид төрөн гарсан. Мартин Лютер Кинг Америкийн хар арьстны иргэний эрхийн төлөө тэмцэлдэв, Нельсон Мандела Өмнөд Африкт Апартайд дэглэмийг төгсгөхийн төлөө тэмцэлдэв, Польшид Лех Валенсия коммунист суртлын эсрэг хүч үл хэрэглэх аргыг тус тус сонгосон юм. Эднээс гадна шашин, нийгэм улс төрийн нэрт зүтгэлтнүүд Төвдийн Далай лам Данзанжамц, Өмнөд Африкийн Дэсмонд Туту, Бирмийн Анг Сан Су Куй нарыг “Гандийн хүүхдүүд” гэдэг. Эдгээр нэр дурдсан хүмүүс бүгдээрээ Нобелийн энх тайвны шагналтнууд юм.

Ганди зөвхөн Энэтхэг түмний шүтээн байсангүй бүх шашин шүтлэгтнүүдийн хувьд ариун гэгээнтэн нь байлаа. Тэрбээр хинди шашинтан байсан боловч “Би зөвхөн хинди биш юм; буддист ч мөн, мусальман ч мөн, христос ч мөн”¹⁰ хэмээн айлдсан байдаг. Тэрбээр хүн болгон мөргөл үйлдэж байх ёстой хэмээн үзэж байсан бөгөөд амьдрал нь тэр чигээрээ мөргөл байв. “Өглөө болгон бидний эхлээд гүйцэтгэх

зүйл болвоос энэ дэлхий дээр би хэнээс ч үл айна. Зөвхөн Бурханаас л айна. Би хэнд ч муу юм хийхгүй. Би хэн нэгний шударга бус явдалтай эвлэрэхгүй. Бус үнэнийг эсэргүүцэн, үнэний хүчээр худлыг байлдан дагуулна. Би зовлонг тэсч давна”.¹¹ хэмээн бодож байхыг сургасан. Тэрбээр хүн хоол ундгүй ганц хоног байж чадна, гэвч мөргөлгүйгээр амьдрах бололцоогүй гэж үзэж байв. Иптэл бишрэл, мөргөлийн хүч чадлыг ухааран сая сая хүнийг нэгтгэн зохион байгуулж соёл иргэншилт хүн төрөлхтөнд үзүүлсэн. Түүний амьдралын хэв маяг тун энгийн байлаа, төрөл бүрийн ногоо, самар, жимс төдийхнөөр хооллодог цагаан хоолтон, өөрийн гараар урласан “чакра” хэмээх хөвөн даавуугаар бие халхлах төдийгөөр хувцасладаг байв. Түүний үзлээр өөрийгөө золиослох явдал бол “амьдралын хууль” юм. Тиймдээ ч бэрх хатуужлаар явж туулсан бурхан болсон Сиддхарта, модонд цовдлуулсан Есүс нарын гэгээрсэн бурхад лугаа адил өөрийгөө золионд гаргаж нийт түмний төлөө зовлон үүрсэн юм. Ганди үнэн хэмээх бурханд мөргөж “оюун ухаан, үг, үйл”¹² гурваа үнэний хүчээр цэнэглэж сая сая хүмүүсийн амьдралд гэрэл гэгээ авчирч, зуун зуундаа үл мартагдах мөнхийн гавъяа байгуулсан.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Stanley Wolpert, *Gandhi's Passion: The Life and Legacy of Mahatma Gandhi* (Oxford University Press 2001), p.265
2. Stanley Wolpert, *Nehru: A Tryst with Destiny* (Oxford University Press 1996). p.429-430
3. Вапу гэдэг нь үгчилвэл “Бага эцэг” гэсэн утгатай.
4. Gandhi, *An Autography: The Story of My Experiments with Truth*. (Beacon Press 1993). p.111
5. 1906 онд Satyagraha хөдөлгөөнийг эхлүүлэхийн өмнөхөн бэлгийн амьдралаас татгалзаж Brahmacharya ёсыг гүйцэтгэх тангараг өргөжээ.
6. Henry David Thoreau, *Civil Disobedience* (Applewood Books 2000)
7. *Collected Works of Mahatma Gandhi* (Ahmedabad 1967-1984). 45, p. 234
8. Мөн тэнд 45, p.133-134
9. Louis Fisher, *The Life of Mahatma Gandhi* (Harper Edition, 1950). Young India, January 8, 1925
10. Louis Fisher, ed. *The Essential Gandhi*. (Vintage Books, 1962). p. XXIII
11. Мөн тэнд, p. 112
12. Gandhi, *An Autography: The Story of My Experiments with Truth*. (Beacon Press 1993). p. 505